



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!


№216 /425/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.12.01

Цаг үе, үйл явдал

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр БНФУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сибастиян Сүрүн, БНФУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Каринь Пүжэ нарыг Батлан хамгаалах яаманд хүлээн авч уулзав.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Монгол Улс, БНФУ-тай 1996 онд батлан хамгаалах салбарт харилцаа тогтоож, 2014 онд хоёр улсын батлан

хамгаалах яамд хооронд хамтран ажиллах гэрээ байгуулж, өнөөдрийг хүртэл хамтын ажиллагаа өргөжин хөгжсөөр байна. Сүүлийн хоёр жил дэлхий нийтийг нөмөрсөн цар тахлын улмаас төлөвлөсөн ажлууд хойшлогдсон хэдий ч өнгөрсөн зун Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан "Эмэгтэй энхийг сахиулагчдын олон улсын чуулга" уулзалт болон "Хааны эрэлд" олон улсын сургуульд төлөөлөгчдөө оролцуулсан явдалд талархаж буйгаа илэрхийлэв. Цаашид хоёр улсын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд дээд, дунд

түвшний төлөөлөгчдийн айлчлалыг тогтмолжуулах, БНФУ-ын цэргийн сургуулиудад монголын цэргийн алба хаагчдыг үргэлжлүүлэн сургах, тоог нэмэгдүүлэх, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд хамтран үүрэг гүйцэтгэх, ҮБХИС-ийн франц хэлний сургалтыг сайжруулах, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллах, ирэх онд Батлан хамгаалах яамд хоорондын Зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах саналтай байгаагаа илэрхийлэв.

БНФУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сибастиян Сүрүн хэлэхдээ, "Эрхэм сайд та, биднийг хүлээн авч, уулзаж буйд талархал илэрхийлэв. Манай Элчин сайдын яамны зүгээс хийж чадах зүйл нь Монгол Улсын тусгаар тогтносон, бие даасан байдлыг дэмжих явдал билээ. Учир нь Монгол, Франц хоёр улс дэлхийн энх тайвны төлөө хүчин зүтгэж, нэгдэж байна. Өчигдөр миний бие ҮБХИС болон Таван Толгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын Нэгдсэн төвийн үйл ажиллагаатай танилцлаа. Тус төвүүд хоёр улсын батлан хамгаалах салбарын цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах, өндөр ач холбогдолтой сургалтын бааз юм. Ирэх онд хамтран хийж хэрэгжүүлэх олон ажлууд дээр тантай санал нэгдсэндээ баяртай байна. Ирэх онд "Хааны эрэлд" олон улсын сургуульд өргөн хүрээнд оролцох болно" гэдгээ уламжиллаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌧️ -28


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 21

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.437	3.442
EUR 🇪🇺	3.586	3.605
CNY 🇨🇳	483	487
RUB 🇷🇺	53.70	54
JPY 🇯🇵	25.10	25.30
KRW 🇰🇷	2.62	2.64

ЗУРХАЙ



2022.12.01 / ПҮРЭВ ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 8

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН ГАХАЙ САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Нас уртасна

Наран ургах, шингэх:

08.20-17.02

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 647,989,682

Эдгэрсэн

Нийт: 625,986,758

Нас барсан

Нийт: 6,640,403

САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДУУЛНА



Өнгөрөгч 11 дүгээр сарын 30-ны өдөр Жендерийн Үндэсний хорооны 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)"-г Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын ажилтан, алба хаагчдад танилцууллаа.

Тус арга хэмжээний үеэр Жендерийн Үндэсний хорооны Ажлын албаны Салбар

дундын бодлого зохицуулагч, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн О.Буянаа уг төлөвлөгөөний хэрэгцээ шаардлага, үндэслэл, зорилго, зорилт, үйл ажиллагаа болон батлан хамгаалах салбарт анхаарч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар танилцууллаа.

Тус стратеги төлөвлөгөө нь Монгол Улсад Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг дэмжиж, ирэх арван жилд төрийн

болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хамтран хэрэгжүүлэх салбар дундын стратеги юм.

Батлан хамгаалах яамнаас "Батлан хамгаалах салбарт жендерийн талаар баримтлах бодлого"-ыг Батлан хамгаалах сайдын 2020 оны тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд цаашид уг стратеги төлөвлөгөөг салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх юм.

Цаг үе, үйл явдал

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНҮҮД ХУРАЛДЛАА



Батлан хамгаалахын сайдын тушаалаар БХЯ-ны ТЗУГ-аас "Төрийн болон албаны нууцыг цахим орчинд хамгаалах нь" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сургалтад БХЯ-ны харьяа байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан 40 гаруй албан тушаалтан танхим болон цахим хэлбэрээр оролцлоо.

Сургалтаар бие бүрэлдэхүүнд Кибер аюулгүй байдлын тухай хууль, төрийн болон албаны нууцыг кибер цахим орчинд хамгаалах, зөврийн төхөөрөмжийг аюулгүй ашиглах зэрэг сэдвийн хүрээнд холбогдох албаны хүмүүс тодорхой мэдээллийг хүргэсэн юм.

Цахим шууданд

ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦЛОО



Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн офицерууд 2022-2023 оны сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу "Даргын бэлтгэл" сургалтын хүрээнд ҮБХИС-ийн Удирдлагын академийн үйл ажиллагаатай танилцаж, дэлхийн улс төр, цэрэг

дайны талаар Удирдлагын академийн багш нараас номын дуу сонслоо.

Мөн энэ өдөр Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн Удирдлагын байр, боловсруулсан баримт бичигтэй танилцаж, туршлага солилцсон юм.

СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Их Эзэн Чингис хааны мэндэлсний 860, Улс тунхагласны 98 жилийн ойг тохилдуулан улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийг бататган бэхжүүлэх, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг гүнзгий судалж, хойч үедээ өвлүүлэх зорилгоор сурталчлан, таниулах

ажлыг зохион байгуулав.

Уг үйл ажиллагааны хүрээнд нийт бие бүрэлдэхүүний дунд оюун ухаан, танин мэдэхүйн хөгжөөнт, цэнгээнт асуулт хариултын "АХА" тэмцээнийг зохион байгуулахад дэслэгч Г.Оюунболд тэргүүн байр, алба хаагч С.Саранзаяа дэд байрт шалгарч бусад нөхдөө манлайлсан юм.

ХАМТАРСАН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Тайван цагт үүрэг биелүүлэх томилгоот бүлгийн бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн Онцгой байдлын Ерөнхий газрын Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвтэй хамтран мэргэжил арга зүйн сургалтыг болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах сэдвийн хүрээнд зохион явууллаа.

Сургалтыг бодит байдалд дөхүүлсэн, үүсэж болзошгүй гамшгийн нөхцөлийг харуулсан дадлагын талбайд цагийн байдал үүсгэж, мэргэжлийн бүрэлдэхүүнтэй хамтран явуулсан нь онцлог байв.

Түүнчлэн ангийн бие бүрэлдэхүүн мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тус сургалтын төвийн үйл ажиллагаа, дадлагын талбай, сургалтын орчин, нөхцөлтэй танилцаж туршлага судалсан юм.



СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №28

ХА ГИЙГҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ

ХА бол дэвсгэр бус үсэг. Тиймээс үгийн хаана ч ямагт ардаа эгшигтэй ордог. Эр, эм үгэнд ордог ХА, ХЭ нь бүтэц зурлагаар бага зэрэг ялгаатай. Эр үгийн ХА-г бичихдээ эхлээд "чих" буюу "дэлбэн чих" зурлага зураад үзгээ салган нум залгаж доош татан шүд гаргаж нуруутай нийлүүлнэ. Харин эм үгийн ХЭ бол шүдгүй, дан "нуман" зурлагаас бүтнэ. ХА, ХЭ-гийн дангаар орох хэлбэрийг зургаас сайтар ажиглаж тогтоогоорой.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, адагт орох ХА, ХЭ, ХИ, ХО, ХУ, ХӨ, ХҮ гэж аялгуулан дуудаж, дүрс зурлагын хувирлыг нүдлэгтүн.

Бичмэл тигээр:

